



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар A/175

Батноров сум

**Газар эзэмшүүлэх эрх
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 66.3 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу "Ресурм минком" ХХК-ны Эхэнбүрд 2 дугаар багийн Бага булаг нэртэй газарт байрлах уул, уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалттай 2304011754 нэгж талбарын дугаар бүхий 10000 м² газрыг хавсралтад дурдсан "Зуунуд Арвижих" ХХК-д шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг "Зуунуд Арвижих" ХХК-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2011 оны А/27 дугаар захирамж, 0227064 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОТГОНБАЯР

230423414